



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/1188

Мандалговь

Нэмэлт гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дугаар хавсралтад үнийн өсөлтийн зөрүү батлагдсан Өлзий хутгийн наран ХХК-ийн гүйцэтгэж буй "Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км Дундговь, Эрдэнэдалай сум" ажлын 2023 онд батлагдсан үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт болох 334,170,175 (гурван зуун гучин дөрвөн сая нэг зуун далан мянга нэг зуун далан тав) төгрөгөөр нэмэлт гэрээ байгуулсугай.

2. Үнийн өсөлтийн нэмэлт санхүүжилт олгоход шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн ажиллахыг "Өлзий хутгийн наран" ХХК-ийн захирал (Ц.Гантулга)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай байгуулсан гэрээнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван), Санхүү төрийн сангийн хэлтсийн ерөнхий санхүүч (С.Адъяасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4813100522